

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ  
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1 Товч танилцуулга

**ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 2.1 Даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөр
- 2.2 Мэдээллийн нэгдсэн сан
- 2.3 Шуурхай алба
- 2.4 Сургалт, сурталчилгаа

**ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1 Санхүүгийн тайлан, үр дүн
- 3.2 Дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт
- 3.3 Гадаад хамтын ажиллагаа

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

## **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:**

### **1.1 Товч танилцуулга**

Улсын Их Хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн анхны бүрэлдэхүүнийг томилж мөн оны 11 сарын 07-ны өдөр Албан журмын даатгагчдын холбоо /ТББ/ (жолоочийн даатгалын санг бүрдүүлж, нөхөн төлбөр олгох, даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагаа, уялдаа холбоог ханган зохион байгуулах, зам тээврийн ослыг бууруулах, жолоочийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх үүрэгтэй, гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө бус)-г үүсгэн байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлж 9072004107 тоот гэрчилгээ олгогдсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрч, Удирдах зөвлөл баталсан дүрмийн дагуу АЖДХолбоо үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд Албан журмын даатгагчдын холбооны үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба, сангийн эрх, үүргийг тодорхойлсон нь тус Холбооны онцлог байдлыг илтгэнэ. Эдгээр алба, сангийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулснаар Холбооны үндсэн эрх, үүрэг хангагдаж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар тус Холбоо нь 12 ажилтны орон тоотой, өөрийн өмчлөлийн ажлын байртай, Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиуд, бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа.

Тайлант хугацаанд “Холбооны ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай”, “Холбооны ажлын албаны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлах тухай”, “Жолоочийн даатгалын сангийн 2025 оны бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийг батлах тухай”, “Холбооны гишүүнээр элсүүлэх тухай”, “Холбооны гишүүний хураамж, татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай”, “Жолоочийн даатгалын сангийн 2025 оны бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийг батлах тухай” нийт Удирдах зөвлөлийн 7 тогтоолыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Холбоонд тайлант хугацаанд нийт ирсэн баримт бичиг 192 байгаагаас хугацаа хэтэрсэн хариу өгөөгүй бичиг байхгүй ба явуулсан баримт бичиг нийт 208 байна.

Нийт 91 өргөдөл, гомдол ирсэн ба үүнээс Холбооны ажилтнуудын 50 хүсэлт, нөхөн төлбөрийн болон бусад 41 өргөдөл хүлээн авч ажилтнуудтай холбоотой 45 тушаал, нөхөн төлбөр болон бусад 36 тушаал шийдвэр гаргасан байна.

Тайлант хугацаанд, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай, аюулгүй ажиллах нөхцлийг хангах зорилгоор ажлын байранд компьютер тоног төхөөрөмж, оффисийн тавилгын худалдан авалт зохион байгуулж 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр “Монтех Дистрибьюшн”ХХК-тай компьютер, тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээ, 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Ровио монголиа”ХХК-тай

оффисийн тавилга нийлүүлэх, мөн оффисийн засвар үйлчилгээ гүйцэтгэх гэрээг тус тус байгуулж гэрээний гүйцэтгэлийг хангуулан ажиллаж байна.

УЗ-ийн 4 дүгээр тогтоолоор “Агис менежмент даатгал”ХХК-ийг Холбооны гишүүнээр элсүүлсэнээр Холбооны орлого буюу 2024 оны гишүүний татвар тогтсон хугацаанд 16 гишүүн даатгагчдаас 17сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн.

## ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөр

Монгол Улсын Их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22.1-д Жолоочийн даатгалын санг үндсэн 4 эх үүсвэрээр бүрдүүлэхээр заасан. Холбоо нь хуулийн дагуу даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулдаг бөгөөд 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.


Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Холбооны удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолын дагуу 2024 онд Жолоочийн даатгалын санд 2,218,000 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан ба тайлант хугацаанд дараах байдлаар орлого төвлөрүүлж ажиллалаа.

#### Жолоочийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт1 /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	558,000	663,877	119.0%
Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого	145,000	190,475	131.4%
Банкны хадгаламжийн хүүний орлого	1,390,000	1,846,976	132.9%
Нөхөн төлбөрийн буцаан төлөлт	125,000	152,040	121.6%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,218,000</b>	<b>2,853,367</b>	<b>128.6%</b>

График 1.



Хуульд заасан эх үүсвэрүүдээс Жолоочийн даатгалын санг бүрдүүлэхэд гишүүн даатгалын компаниудтай хамтран ажилласнаар 2024 оны жилийн эцсийн байдлаар Санд 2,8 тэрбум төгрөг төвлөрүүлж Орлогын төлөвлөгөөг 635,967.0 мянган төгрөгөөр давуулж 128.6%-иар биелүүллээ.

Орлогын гүйцэтгэлийн 64.7 хувийг сангийн хөрөнгийг байршуулсан банкнуудаас орж ирж байгаа хүүний орлого эзэлж байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан эх үүсвэрийг 2024 онд бүрэн төвлөрүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөг жигд давуулж биелүүлэхэд ажил хариуцсан хүмүүсийн идэвх чармайлтаас хамаарсан төдийгүй сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулах ажлыг сайн зохион байгуулж банкны хадгаламжийн хүүг судалгаа, цаашдын хандлагад тулгуурласан бодлого явуулсаны үр дүнд 456,976.0 мянган төгрөгөөр давуулж биелүүлэв.

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагчаас санд төвлөрүүлэх хөрөнгийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтран баталдаг хөрөнгө төвлөрүүлэх тухай тушаалын хэрэгжилт дараах байдалтай байна.

### Даатгалын компаниудын 2024 онд хөрөнгө төвлөрүүлсэн байдал

Хүснэгт2 /төгрөгөөр/

№	Даатгагчийн нэр	ОТХураамж	ЖДСанд төвлөрүүлэх хөрөнгө	2024.12.31
1	Мөнх даатгал ХХК	2,997,945,089.60	47,967,121.43	
2	Номин даатгал ХХК	5,452,852,330.40	87,245,637.29	
3	Миг даатгал ХХК	6,097,115,126.70	97,553,842.03	
4	Ард даатгал ХХК	4,837,779,412.20	77,404,470.60	40,000,000.00
5	Монгол даатгал ХХК	4,685,737,316.60	74,971,797.07	22,491,539.13
6	Тэнгэр даатгал ХХК	1,738,403,531.20	27,814,456.50	
7	Бодь даатгал ХХК	3,660,542,296.20	58,568,676.74	
8	Монре даатгал ХХК	2,020,007,209.30	32,320,115.35	
9	Улаанбаатар хотын даатгал ХХК	137,737,767.50	2,203,804.28	
10	Практикал даатгал ХХК	3,894,667,459.50	62,314,679.35	
11	Амар даатгал ХХК	1,450,119,214.50	23,201,907.43	
12	Мандал даатгал ХХК	1,688,279,473.00	27,012,471.57	
13	Ган зам даатгал ХХК	49,026,495.40	784,423.93	784,423.93
14	Хаан даатгал ХХК	1,967,000,823.20	31,472,013.17	31,472,013.17
15	Агула даатгал	815,103,497.60	13,041,655.96	13,041,656.00
	<b>Нийт</b>	<b>41,492,317,042.90</b>	<b>663,877,072.69</b>	<b>54,747,976.23</b>

Жич: Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 466/226 дугаар тушаалаар (ЖДТХ-22.1.1) жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчаас 2024 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн дүнгээс 1,6 хувиар тооцож 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр төвлөрүүлэх даалгавар өгөгдсөн боловч хэрэгжүүлсэн байдал дээрх хүснэгтээс харагдаж байна.

Удирдах зөвлөлөөс 2012 онд баталсан Холбооны гишүүн тус бүр жил тутам 1 сая төгрөгийн татварыг Холбоонд төлөх тогтоолын дагуу гишүүдээс төвлөрүүлэх 2024 оны гишүүний татварын орлого 17,0 сая төгрөг бүрэн төвлөрсөн.

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг холбогдох журамд заасны дагуу Төрийн банк, Хаан банк, Голомт банк болон Сэндли ББСБ-д харилцах, хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалтын хэлбэрээр байршуулж байна.

Чингис хаан банк дахь хадгаламжийн үлдэгдэл 5,434,539.9 мянган төгрөгийг барагдуулахаар, тус банктай 2020 оны 11 сарын 04-ний өдөр УБ хот, Сүхбаатар дүүргийн, Чингисийн өргөн чөлөө гудамж, 17 байр 13 тоот, 476,7 мкв талбайтай оффисын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 2,181,856.0 мянган төгрөгөөр үнэлэн, харилцан ойлголцож “Өр төлбөрт шилжүүлэх тухай гэрээ”, 2022 оны 05 сарын 12-ны өдөр, “Си эф си” ХХК-ийн өмчлөлийн, Хан Уул дүүргийн 3-р хороо, Энгельсийн гудамж 8 тоот хаягт байрлалтай 15 давхар оффис, үйлчилгээ, орон сууцны барилгаас нийт 3,639,568.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 3 давхарт байрлах 470.9 м.кв талбайтай үйлчилгээний заал, 7 давхарт байрлалтай 362,9 м.кв талбайтай оффисын талбайг тус банкинд байршуулсан хөрөнгөнийхөө үлдэх хэсэгт тооцон авахаар банк, барилгын өмчлөгчтэй 3 талт гэрээг Чингис хаан банк, “Си эф си” ХХК -тай тус тус байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж Чингис хаан банкнаас 2024 оны 4-р сарын 26-ны өдөр гэрээгээр хүлээлгэн өгөх үл хөдлөх хөрөнгийг хүлээлцэх тухай албан тоот ирүүлсэн. Энэ хугацаанд Холбооны зүгээс Чингис хаан банкинд дараах албан тоотуудыг хүргүүлсэн байна. Үүнд: 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/45 албан тоот “Хүсэлт хүргүүлэх тухай”, 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 1/85 албан тоот “Гэрээний хэрэгжилтийг хангах тухай”, 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/121 тоот “Мэдээлэл хүсэх тухай” албан шаардлагуудыг явуулсан байна.

Үндэсний хөрөнгө оруулалтын банк дахь хадгаламжийн үлдэгдэл 112,614.6 мянга төгрөг байна. Холбооны зүгээс дараах албан тоотуудыг явуулсан. 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/25 тоот, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 1/100 албан тоотуудаар тус тус “Хөрөнгө татах тухай” албан мэдэгдэл. 2024 оны эхний хагас жилд Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас 2 удаагийн гүйлгээгээр 10,0 сая төгрөг татан төвлөрүүлсэн. Мөн Үндэсний хөрөнгө оруулалтын банк нь Албан журмын даатгагчдын холбооны эзэмшилд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 24/122 тоот “Төлбөр барагдуулах гэрээ”-гээр харилцах дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийн холбогдох хэсгийг хөрөнгөөр барагдуулахыг зөвшөөрсөний үндсэн дээр 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 24/123 тоот “Эрх шилжүүлэх гэрээ”-гээр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороонд байрлах “Гарден хилл” хотхоны орон сууцны барилгын 2-р ээлжийн 661-р байрны 1 давхарын 101 тоот 40.22м.кв 2 өрөө орон сууцыг 118,649,000.0/Нэг зуун арван найман сая зургаан зуун дөчин есөн мянга/ төгрөгт дүйцүүлэн шилжүүлэн өгсөн.

Холбооны 2024 оны жилийн эцсийн санхүү, нийгмийн даатгал, татварын тайлангуудыг нэгтгэн гаргаж эрх бүхий газруудад тогтсон хугацаанд нь багтаан хүргүүлсэн. 2023 оны санхүүгийн тайланд “Шонхор үнэлгээ аудит” ХХК-аар аудит хийлгэж дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Удирдах зөвлөлийн гишүүдэд хүргүүлэн, олон нийтэд мэдээлсэн. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж мөрдөн ажиллалаа.

Мөн 2024 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайлангуудыг бэлтгэн гаргаж Санхүүгийн зохицуулах хороо зэрэг эрх бүхий байгууллагуудад холбогдох тайлангуудыг хүргүүлж ажиллалаа.

Холбооны 2025 оны орлого зардлын төсвийн төслийг боловсруулж удирдлагад танилцуулж, Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, Удирдах зөвлөлийн хурлаар батлууллаа.

## 2.2 Мэдээллийн нэгдсэн сан:

Мэдээллийн сан нь Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup>.3.1-д заасан чиг үүрэг болон Албан журмын даатгагчдын холбооны гишүүн, даатгагч, даатгуулагч нарт өөртэй нь холбоотой мэдээллээр, жолоочийн даатгалтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй төрийн байгууллага, албан тушаалтанд үнэ төлбөргүй мэдээллээр хангах үүрэг гүйцэтгэхээс гадна Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, хяналт тавих үндсэн үүрэгтэй мэдээллийн сан үндсэн үүргээ өөрийн боловсруулж нэвтрүүлсэн МИИС системийг ашиглан хэрэгжүүлж байна.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн Дата өгөгдлөөр нэгдсэн тайлан дүн, мэдээг улирал тутам өссөн дүнгээр гаргаж нэгтгэдэг. Үүнд:

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниуд 2024 онд нийт 909,409 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 55,6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн. Даатгалын компани тус бүрээр ангилж харуулбал:

№	Даатгалын компани	Хувь хүн		Хуулийн этгээл		Мэргэцсэн С D		Дамжин өнгөрөх		Нийт	
		Даатгалын гэрээний дээ	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний дээ	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний дээ	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний дээ	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний дээ	Хураамжийн дүн
1	Амар даатгал	5,581	251,147,809	7,505	992,916,451	879	22,446,215	329	96,109,547	14,294	1,362,620,022
2	Агула Даатгал	8,097	621,946,080	4,764	554,721,454	115	3,466,154	0	0	12,976	1,180,133,688
3	Ард даатгал	147,776	7,434,857,387	45,732	4,453,878,488	2,411	66,476,937	16	3,817,327	195,935	11,959,030,139
4	Бодь даатгал	28,448	1,027,266,386	7,875	772,461,091	997	25,216,285	21	2,491,418	37,341	1,827,435,179
5	Ган Зам Даатгал	96	4,224,483	424	43,265,433	57	1,383,690	0	0	577	48,873,606
6	Минг даатгал	110,178	5,121,671,024	46,169	4,435,361,919	3,263	81,524,969	30	3,156,307	159,640	9,641,714,219
7	Мандал даатгал	1,260	78,038,933	9,588	942,934,472	245	6,953,099	1	79,472	11,094	1,028,005,996
8	Монгол даатгал	71,527	2,770,261,093	22,200	2,204,406,156	2,127	54,995,318	465	79,925,450	96,319	5,109,588,016
9	Монре даатгал	8,350	408,029,812	3,485	381,322,235	495	12,040,131	9	933,074	12,339	802,325,252
10	Мөнх даатгал	47,381	2,045,176,491	18,835	1,984,749,573	1,861	45,394,129	5,629	692,754,124	73,706	4,768,074,317
11	Номин даатгал	49,040	2,536,590,745	17,620	1,739,145,675	1,398	37,338,991	10	2,263,833	68,068	4,315,339,245
12	Практикалдаатгал	49,833	1,981,233,429	18,116	1,612,882,697	630	15,449,442	92	10,297,357	68,671	3,619,862,925
13	Тэнгэр даатгал	10,799	510,895,715	7,669	845,114,004	341	8,461,447	1	150,579	18,810	1,364,621,745
14	Улаанбаатар хотын даатгал	71,270	3,658,611,586	17,130	1,669,417,663	682	19,581,328	5	649,279	89,087	5,348,259,856
15	Хаан даатгал	23,669	895,342,806	23,025	2,257,049,014	3,836	112,399,221	22	4,216,346	50,552	3,269,007,387
Нийт		633,305	29,345,293,799	250,137	24,889,626,326	19,337	513,127,355	6,630	896,844,112	909,409	55,644,891,592

Гишүүн 15 даатгалын компаниас 2024 онд нийт 27,427 жолоочийн даатгалын тохиолдол гарч 32,5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хохирлыг эрсдэлийн ангилал тус бүрээр хувьчлан авч үзвэл нийт даатгалын тохиолдлын 98.7% нь тээврийн хэрэгсэлд учруулсан хохирол байгаа бол бусад хөрөнгөд хохирол учруулсан даатгалын тохиолдол 1,04%, бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирол 0,24%-ийг тус тус эзлээд байна. Компани тус бүрээр, эрсдлийг ангилж харуулбал:

№	Даатгалын компани	Тээврийн хэрэгсэл		Эд хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт	
		Тохироллын тоо	НТ дүн	Тохироллын тоо	НТ дүн	Тохироллын тоо	НТ дүн	Тохироллын тоо	НТ дүн	Тохироллын тоо	Нөхөн гөлбөрийн дүн
1	Амар даатгал	607	793,089,014	7	26,101,474	0	0	1	840,000	615	820,030,488
2	Агула Даатгал	613	743,193,676	3	5,913,708	0	0	1	374,200	617	749,481,584
3	Ард даатгал	6,304	7,506,572,884	63	94,391,690	1	5,000,000	14	34,487,589	6,382	7,640,452,163
4	Бодь даатгал	926	1,168,009,666	15	18,187,171	1	100	2	5,000,100	944	1,191,197,037
5	Ган Зам Даатгал	17	34,717,496	1	700,000	0	0	2	1,729,250	20	37,146,746
6	МИГ даатгал	3,381	3,969,110,589	30	48,272,158	1	5,000,000	8	19,356,642	3,420	4,041,739,389
7	Мандал даатгал	1,235	1,227,100,600	20	19,719,536	4	10,173,000	1	1,340,871	1,260	1,258,334,007
8	Монгол даатгал	2,882	3,155,803,073	28	35,338,453	1	5,000,000	7	19,360,150	2,918	3,215,501,676
9	Монре даатгал	235	268,142,547	1	200,000	0	0	0	0	236	268,342,547
10	Мөнх даатгал	2,124	2,439,425,029	17	39,941,485	1	5,000,000	7	9,496,990	2,149	2,493,863,504
11	Номин даатгал	2,369	2,864,270,905	22	42,558,564	0	0	6	13,522,000	2,397	2,920,351,469
12	Практикалдаатгал	2,258	2,676,469,699	17	47,123,609	0	0	6	10,302,442	2,281	2,733,895,750
13	Тэнгэр даатгал	862	1,156,207,021	37	50,124,022	0	0	0	0	899	1,206,331,043
14	Улаанбаатар хотын даатгал	1,370	1,650,835,713	4	5,789,000	0	0	0	0	1,374	1,656,624,713
15	Хаан даатгал	1,893	2,314,262,197	20	21,888,929	0	0	2	727,800	1,915	2,336,878,926
	<b>Нийт</b>	<b>27,076</b>	<b>31,967,210,109</b>	<b>285</b>	<b>456,249,799</b>	<b>9</b>	<b>30,173,100</b>	<b>57</b>	<b>116,538,034</b>	<b>27,427</b>	<b>32,570,171,042</b>

Жолоочийн даатгалын нийт Хувь хүний 563,543, хуулийн этгээдийн 213,447 мэргэшсэн болон C,D ангиллын жолоочийн 16,768 дамжин өнгөрөхийн 764 гэрээ бүртгэгджээ. Компани тус бүрээр ангилбал:

№	Даатгалын компани	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн C D		Дамжин өнгөрөх		Нийт	
		Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Амар даатгал	5,061	226,767,707	6,331	821,656,894	713	18,293,660	0	0	12,105	1,066,718,261
2	Агула Даатгал	6,902	530,824,889	4,203	489,287,351	113	3,392,729	0	0	11,218	1,023,504,969
3	Ард даатгал	129,047	6,495,412,976	39,036	3,826,027,236	2,196	60,564,824	0	0	170,279	10,382,005,036
4	Бодь даатгал	26,666	960,474,636	7,198	707,111,402	892	22,682,958	2	481,140	34,758	1,690,750,135
5	Ган Зам Даатгал	86	3,814,029	407	41,521,863	53	1,274,790	0	0	546	46,610,682
6	МИГ даатгал	101,813	4,738,557,356	40,715	3,922,183,441	2,871	71,195,820	0	0	145,399	8,731,936,617
7	Мандал даатгал	783	48,074,330	7,218	710,764,622	227	6,453,149	1	79,472	8,229	765,371,573
8	Монгол даатгал	64,105	2,445,095,665	18,955	1,874,519,912	1,821	47,285,776	49	19,385,401	84,930	4,386,286,753
9	Монре даатгал	6,743	333,005,867	2,891	320,566,039	420	10,161,937	0	0	10,054	663,733,843
10	Мөнх даатгал	41,865	1,786,790,103	16,095	1,696,262,745	1,722	41,887,054	705	99,321,568	60,387	3,624,261,469
11	Номин даатгал	42,637	2,220,430,379	14,985	1,475,146,930	1,170	31,033,765	3	665,874	58,795	3,727,276,948
12	Практикалдаатгал	44,115	1,731,010,817	15,010	1,347,929,632	496	11,746,430	2	372,938	59,623	3,091,059,816
13	Тэнгэр даатгал	8,712	394,093,831	5,674	607,559,451	271	6,604,537	0	0	14,657	1,008,257,819
14	Улаанбаатар хотын даатгал	63,407	3,263,019,139	14,968	1,465,819,809	656	18,900,538	1	146,718	79,032	4,747,886,204
15	Хаан даатгал	21,601	808,947,646	19,761	1,915,004,832	3,147	91,770,515	1	449,064	44,510	2,816,172,057
	<b>Нийт</b>	<b>563,543</b>	<b>25,986,319,370</b>	<b>213,447</b>	<b>21,221,362,158</b>	<b>16,768</b>	<b>443,248,481</b>	<b>764</b>	<b>120,902,174</b>	<b>794,522</b>	<b>47,771,832,183</b>

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 34 зуучийн компани 2024 оны жилийн эцсийн байдлаар 305,000 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 18,3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн. Нийт хураамжийн дүнд эзлэх хувь 32,9% байна.

Мэдээллийн сангийн мэдээллийг боловсруулж гишүүн 15 даатгалын компаниас МИИС системд нийлүүлсэн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийн тоо, дүн зэрэг мэдээллийн зөрүү, тайлан мэдээ, танилцуулга нэгтгэж боловсруулахад шаардлага хангахгүйгээс тулгалт хийж даатгалын компаниудын гэрээ, нөхөн төлбөр хариуцсан ажилтнуудад мэдээллээ нягталж оруулах шаардлага тавьж мэдээллийн сангийн журам, МИИС систем ашиглах гэрээний үүргээ биелүүлж, үнэн зөв тайлан гаргах, мэдээллийн санд нийлүүлэх талаар уулзалт зохион байгуулж анхааруулан хамтран ажиллаж байна.

Мөн улирал бүрээр мэдээллийн сангийн тоо статистик мэдээг гаргасан. Холбооны цахим хуудас болон веб сайт дээр сар бүрийн жолоочийн даатгалын хамрагдалт болон нөхөн төлбөрийн мэдээллийг нийтэлсэн. СЗХ руу 7 хоног бүр мэдээллийн санд бүртгэгдсэн жолоочийн даатгалын мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай гэрээ байгуулан, Төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холболт хийж МИИС системээс иргэний болон тээврийн хэрэгслийн мэдээллийг татан авдаг болсон байгаа. МИИС системийг cloud.mn үүлэн тооцооллын серверт бүрэн шилжүүлсэн бөгөөд ингэснээр биет сервер, сүлжээний тоног төхөөрөмж болон серверийн өрөөтэй холбоотой гарах зардлыг бууруулсан. Мөн сүлжээний нууцлал аюулгүй байдал, өгөгдлийн сангийн нөөцлөх чадварыг дээшлүүлж, системийн тасралтгүй найдвартай байдлыг сайжруулсан ба тухай бүрт мэдээллийн аюулгүй байдлын сургалтад хамруулж ажилласан. МИИС системийн өгөгдлийн санг Oracle өгөгдлийн сангаас PostgreSQL болгон шинэчилсэн. Ингэснээр жил болгон төлдөг Oracle support төлбөрийг төлөх шаардлагагүй болсон бөгөөд өгөгдлийн сангийн бүтэц оновчтой болж мэдээлэл дамжуулах хурд сайжирсан.

Тайлант хугацаанд Мэдээллийн сан, судалгааны алба нь МИИС системийн эх код, өгөгдлийн сан, сервер систем болон сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын бүрэн аудит хийлгэсэн бөгөөд тухайн шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн системийн шинэчлэлийг хийж дуусгалаа.

Шинэ өгөгдлийн сангийн бүтцэд суурилан МИИС системээс И-Монголиа академид жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний мэдээлэл, нөхөн төлбөрийн мэдээлэл болон гэрээ дуусаж буй тухай анхааруулга илгээх чадалтай API gateway системийг хөгжүүлсэн. Улмаар И-Монголиа академид үндэсний дата төвөөр дамжуулан дээрх мэдээллүүдийг нийлүүлж байна. API gateway системээр бусад байгууллагуудад мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүллээ. Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монголиа академи болон Төрийн цахим үйлчилгээний зохицуулах хороотой байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд И-Монголиа 4.0 платформд жолоочийн албан журмын хариуцлагын гэрээний мэдээллийг харуулах системийг боловсруулан, И-Монголиа академид мэдээлэл нийлүүлж байна. Мөн цахим даатгал хийх боломж бүхий MINI APP хөгжүүлж, туршилт хийж байна.

МИИС системийг ХУР, ДАН системтэй холбож мэдээлэл дамжуулдаг болгох ажлыг бүрэн хийж дуусгалаа. Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Олон Улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандарт нэвтрүүлэх ажил хийгдэж байна. ISO27001 нэвтрүүлэх ажлын хэсэгт Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулсан.

Холбооны цахим хуудсыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэн 100% ашиглалтад оруулж иргэд, даатгуулагчдыг мэдээ, мэдээллээр хангаж байна.

Үйлдлийн систем, хэрэглээний программ, төхөөрөмжийн системийн шинэчлэлт, сунгалт /update/, сайжруулалтыг цаг хугацаанд нь хийсэн. ЦЕГ, АТҮТ болон Нийслэлийн авто тээврийн газартай холболт хийж даатгалын гэрээний мэдээлэл солилцож байна. Жолоочийн даатгалын сангийн мэдээллийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/24 тоот албан бичгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хүргүүлсэн.

МИИС систем шинэчлэх ажлын хүрээнд нийт 5 удаагийн сургалт, уулзалт зохион байгуулж гишүүдийн саналыг хүлээн авч системд тусгасан. Үүнд: 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр Банкуудын холбоонд, 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Холбооны байранд, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус ZOOM

app-р сургалт болон уулзалтуудыг зохион байгуулсан. Мөн даатгалын компаниуд болон зуучлагч байгууллагуудын мэдээлэл солилцох группыг үүсгэн тулгарсан асуудал, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан.


МИИС системийн шинэчлэлийн хүрээнд жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний мэдээллийг хариулах Дашбоард нэвтрүүлэх ажил хийгдэж байна.

### 2.3 Шуурхай алба

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 16 компаний оператор, менежерүүдтэй холбогдож дуудлага хэрхэн авдаг, нөхөн төлбөрийн бүрдүүлбэр хэрхэн явагддаг талаар мэдээлэл цуглуулж судалгаа хийлээ.

70101177, 18001177 тусгай дугаарт нийт 6,149 дуудлага хүлээн авч MIIS программд бүртгэн ажилласан. Дуудлагын тоог графикаар харуулбал:

График 9.



Тайлант хугацаанд Шуурхай дуудлагын төвийн 1800-1177, 70101177 дугааруудад хандсан даатгагч, даатгуулагч, жолооч, иргэдэд жолоочийн даатгалын мэдээллийн MIIS системээс зохих мэдээлэл, лавлагааг нийт 6,149 удаа өгч, даатгалын тохиолдол гаргаад хаана даатгуулснаа шалгуулсан жолоочид даатгагч нарын утасны дугаар, даатгалын хугацаа дууссан хүмүүст холбооны даатгалын сангаас буцаан төлөх нөхцөлтэй нөхөн төлбөр гаргуулах боломжтойг зөвлөж, нөхөн төлбөр авч байсан лавлагаа, мэргэшсэн жолоочийн даатгалын лавлагаа, сануулах мессеж явуулсаны дагуу жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. 1800-1177 дуудлагын төв нь Callpro компанитай хамтран ажиллах гэрээг цуцалж, 2024 оны 2 дугаар сараас эхлэн “Телко коммуникэшнс” ХХК компанитай хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна. Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хугацаа дууссан **13,330** иргэнд даатгалын гэрээгээ сунгах сануулга мессеж илгээжээ.

### 2.4 Сургалт, суртчилгаа

2024 онд сургалт сурталчилгааны ажлын хүрээнд сургалтын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг ханган ажиллалаа. Үүнд:

Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирал М.Өлзийбат Япон, Хонг-Конг, БНСУ-ын сайн туршлага судлах, нэвтрүүлэх, тус Холбооны үйл ажиллагааг сурталчлах, олон талт хамтын ажиллагаа бий болгох, хамтран ажиллах хүрээг тодорхойлох зорилгоор олон улсын даатгалын байгууллагууд, экспертүүдтэй санал солилцож эрсдэлийн судалгаа, таамаглал, тооцоолол, актуарын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үнэ тогтоох, бодлогын, иргэдийн скоринг, итгэлцүүр тооцох, хиймэл оюун ухаан, замын хөдөлгөөний зөрчлийн үнэлгээний системийн талаар мэдээлэл солилцон цаашид хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх талаар судалгаа хийж ирсэн.

Мөн “Түгжрэлийг бууруулахад иншуртекийн эерэг нөлөө” салбар хуралдаанд Гүйцэтгэх захирал М.Өлзийбат панелистаар уригдаж, мэдээллийн сангийн ахлах администратор О.Мөнхбат хүний нөөцийн менежер С.Ариунтуяа нар оролцсон. Салбар хуралдаанаар, УБ хотын замын хөдөлгөөний ослын үед технологи ашиглан хялбар шийдвэрлэх, зам тээврийн ослын тохиолдлыг баталгаажуулахад Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс даатгагчдад зориулсан шийдлийг бий болгосон тухай танилцуулж, зам тээврийн ослоос үүдэн тохиолдож буй эрсдэлийг хотын газрын зураг дээр визуал байдлаар олон нийтэд нээлттэй болгон эрсдэлээс зайлсхийх, бууруулдаг болох ажлуудыг хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан. Мөн, хариуцлагагүй жолоочийг даатгалын гэрээний үүргээр хариуцлагажуулах хууль тогтоомжийг хэлэлцлээ.

**Сургалтын тайлан:** 2024 онд Цагдаагийн Ерөнхий газар, Юбикаб, Монголын Үйлдвэрчний эвлэл зэрэг байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нийт 11 ААН, байгууллага, хуулийн этгээд, зорилтот бүлэгт чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж, Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийг 2903 хүнд хүргэж ажилласан байна. Зохион байгуулсан сургалтуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

№	Хугацаа	Сургалтын чиглэл, зорилго	Зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн	Хамтрагч байгууллага	Хамрагдсан хүний тоо
1	2023.12.14	Жолоодох эрхийн болон эрхээ хасуулсан иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрт “Жолоочийн хариуцлагын даатгал” сэдвийг оруулж батлах	Жолоодох эрх, зөрчлийн оноогоо сэргээхээр бүртгүүлсэн жолооч нарт хийсэн сургалт	“Зөв сургалт, хөгжлийн төв” НҮТББ	8
2	2024.03.03	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдол, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх	Такси жолоочийн апплейкшнд бүртгэлтэй жолооч нарт хийсэн сургалт	Юбикаб	2000
3	2024.04.17	Хөдөө, орон нутгийн замд гарч буй зам, тээврийн осол, даатгалын тохиолдлыг бууруулах	Хот хоорондын тээвэр эрхлэгчдэд “Хариуцлагын даатгал таныг хамгаална” сургалт	Хот хоорондын тээвэр эрхлэгчдийн холбоо, Монголын тээврийн холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоодуудтай	80
4	2024.06.10	Зам тээврийн осол их гарч буй аймгуудын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Баянхонгор аймгийн даатгагч, даатгуулагчдад уулзалт зөвлөгөөн	-	15
5	2024.06.12	Зам тээврийн осол их гарч буй аймгуудын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Говь-Алтай аймгийн даатгагч, даатгуулагчдад уулзалт зөвлөгөөн	Говь-Алтай аймгийн Цагдаагийн байгууллага	45
6	2024.06.14	Зам тээврийн осол их гарч буй аймгуудын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Увс аймгийн даатгагч, даатгуулагчдад уулзалт зөвлөгөөн	Увс аймгийн Цагдаагийн байгууллага	40
7	2024.06.16	Зам тээврийн осол их гарч буй аймгуудын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Ховд аймгийн даатгагч, даатгуулагчдад уулзалт зөвлөгөөн	-	15
8	2024.06.19	Зам тээврийн осол их гарч буй аймгуудын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Завхан аймгийн даатгагч, даатгуулагчдад уулзалт зөвлөгөөн	-	15
9	2024.09.17	Зорилтот бүлгийн иргэдэд даатгалын ач холбогдлыг таниулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах	ТЦА	80
10	2024.09.18	Дуудлагын такси үйлчилгээ эрхлэгчдийн даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Дархан-Уул аймгийн дуудлагын жолооч нарт сургалт хийх	ТЦА	40

11	2024.10.10	Нүүрс тээврийн жолооч нарын даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Өмнөговь аймагт уул уурхай, нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулж буй компаниудын жолооч нарт сургалт явуулах	МҮЭ, ТЦА	35
12	2024.10.28-2024.11.05	Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Цагдаагийн байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг хэлэлцэх	ЦЕГ-тай хамтран "Өдөр бүр өчигдрөөсөө илүү байя" аяны хүрээнд даатгалын сургалт	ЦЕГ	300
13	2024.11.06	Такси үйлчилгээний жолооч нарт даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	"VIP такси сервис" ХХК-ийн такси үйлчилгээний жолооч нарт сургалт зохион байгуулах	Бодь даатгал, ТЦА	22
14	2024.11.07	Нийтийн тээврийн жолооч нарт даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	"Ханбогд" ХХК-ийн "Оюу Толгой"-н ажилчдыг тээвэрлэдэг автобусны жолооч нарт сургалт зохион байгуулах	Бодь даатгал, ТЦА	20
15	2024.11.29	Борлуулалт, түгээлтийн жолооч нарт даатгалын тохиолдлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Монголиан стар дистрибьюшн ХХК түгээлтийн жолооч	Бодь даатгал, ТЦА	17
16	2024.12.03	Цагдаагийн байгууллагын албан хаагчдын Жолоочийн даатгалын тухай хуулийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг хэлэлцэх	Шилдэг зохицуулагч - 2024 ТЦА-д сургалт хийх	ТЦА	70
17	2024.12.05	А ангиллын тээврийн хэрэгслийн даатгалын тохиолдлыг бууруулах, ирээдүйн даатгуулагчдад даатгалын ач холбогдлыг танин мэдүүлэх, хүүхэд зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх	Налайх дүүргийн ЕБС	ТЦА	50
18	2024.12.19	СЗХ-ны 493 дугаар тогтоолоор батлагдсан жуомын өөрчлөлтийг танилцуулах	Даатгалын зуучлагч нарт журмын танилцуулга цахим сургалт	СЗХ	27
19	2024.12.20	СЗХ-ны 493 дугаар тогтоолоор батлагдсан жуомын өөрчлөлтийг танилцуулах	Даатгалын төлөөлөгч нарт журмын танилцуулга цахим сургалт	СЗХ	24
<b>Сургалт, хэлэлцүүлэгүүдэд хамрагдсан нийт хүний тоо</b>					<b>2903</b>



Монгол Улсад даатгалын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээнд “Зам тээврийн эрсдэл” бүүтийг хариуцан зохион байгуулалтын ажлын хэсэгт ажилласан. Тус арга хэмжээний үеэр олон нийтэд танилцуулагдах холбооны үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулсан 2 минут 30 секундны бичлэгний зохиолыг гаргасан.

Хүснэгт 14

№	Сурталчилгааны ажил	
1	Ami.mn албан ёсны веб хуудас Албан журмын даатгагчдын холбоо пэйж хуудас	Жолдоочийн хариуцлагын даатгалын тухай 5 постер бэлтгэж байршуулсан. Жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллээ цахимаар шалгах боломжтой тухай рийл хийж, цахим байршуулахад бэлэн болсон. ЦЕГ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жолооч, даатгуулагч нарт анхааруулга, сэрэмжлүүлэг бүхий постер, шторк хийж байршуулсан.
2	NEWS CHANEL, MNB, TV9 Телевиз, Zugii.mn, UBN.mn ICON.mn Сайт	Монгол коммент нэвтрүүлгээр жолоочийн хариуцлагын даатгалын талаар хөндөж яриулж, 8 төрлийн мэдээ бэлтгэн, титр болон мэдээгээр олон нийтэд хүргэсэн.
3	Авторадио	Жолоочийн даатгал- Монголын даатгалын холбооны ерөнхийлөгч Т.Батзул Нөхөн төлбөр- UB даатгал компаний нөхөн төлбөрийн газрын захирал Ж.Даваасүрэн Нийслэлийн ЗД-ийн Захирамж- ТЦА-ны Зөрчил шалгах хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Энх-Амар Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ- Улаанбаатар хотын даатгал ХХК-ийн захирал Н.Нацагдорж Даатгалын гэрээний анхаарах зүйл-Монголын зуулчлалын удирдах зөвлөлийн гишүүн Д.Отгонбаяр
	Гэр бүлийн радио	АЖДХ-ны зөвлөх П.Ууганбаяр, “Агула” даатгалын компанийн маркетинг хариуцсан захирал Б.Цацрал Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал Монголын даатгалын зах зээлийн холбооны дарга Б.Жавхлантөгс нар олон нийтэд жолоочийн даатгалын тухай ойлголт болон Даатгалын салбарын 90 жилийн ойн талаарх мэдээ мэдээллийг радиогийн нэвтрүүлгээр олон нийтэд хүргэсэн. Нэг сарын хугацаанд “Хариуцлагын даатгал таныг хамгаална” аман сурталчилгааг өдөр бүр давтамжит тоогоор цацуулсан.

## ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Санхүүгийн тайлан, үр дүн

Холбооны жолоочийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль Төрийн бус байгууллагын хууль, холбогдох бусад хууль болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлан анхан шатны баримтад тулгуурлан бүртгэж тайлагнав.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайд, Зам тээврийн сайдын хамтарсан 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 20/19 дүгээр тушаалаар батлагдсан “Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх” журмыг баримтлан

жолоочийн даатгалын сангийн орлогыг төвлөрүүлж, жолоочийн даатгал тухай хуулийн 18 дугаар зүйлийг баримтлан сангаас нөхөн төлбөрийг олгож, 23 дугаар зүйлийг баримтлан сангаас зарцуулалт хийж ажиллалаа.

2024 онд, Жолоочийн даатгалын санд нийт 2,853,367 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөг 128.6%-иар биелүүлсэн болно. /Хүснэгт2/

Жолоочийн даатгалын сангаас Жолоочийн даатгалын тухай хуулийн 18-р зүйлийг үндэслэн даатгалын тохиолдлын хохирогчид 106,149.4 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгож, буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх гэрээ байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласнаар 152,040.0 мянган төгрөгийг жолоочийн даатгалын санд буцаан төвлөрүүлэв.

2024 онд үндсэн үйл ажиллагааны болон, хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж ажиллахад анхаарсан бөгөөд 2024 оны нийт зардлыг 2,103,146 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэл 1,835,751 мянган төгрөг байна.

Үүнээс үйл ажиллагааны зардлын төсөв 1,773,327 мянга төгрөг, гүйцэтгэл нь 1,515,883 мянган төгрөг байна.

Холбооны 2024 оны батлагдсан төсвөөс үйл ажиллагааны зардлыг 257,444 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Зарим тодорхой зардлууд хэрхэн хэмнэгдсэн талаар дараах хүснэгтээс харж болно.

### Жолоочийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн зардлын төсөв, түүний гүйцэтгэл

Хүснэгт 15 / мян.төг/

д/д	Зардлын зүйл, төрөл	Мөрийн дугаар	Төсөв	Зардлын гүйцэтгэл	Хэтрэлт - Хэмнэлт +
1	Ажиллагсдын цалин хөлс	1	716,920	592,311	124,609
	<i>Удирдах зөвлөлийн гишүүдийн нөхөн төлбөр</i>	2	51,600	21,500	30,100
	<i>Ажлын алба</i>	3	665,320	570,811	94,509
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	4	89,512	62,764	26,748
	<i>Удирдах зөвлөл</i>	5	6,347	2,580	3,767
	<i>Ажлын алба</i>	6	83,165	60,184	22,981
3	Томилолтын зардал	7	100,000	53,968	46,032
4	Захиргаа аж ахуйн зардал	8	1,400	1,400	0
5	Бичиг хэргийн зардал	9	6,600	2,862	3,738
	Даатгал, оношлогоо, татвар, аудит	10	170,826	211,323	(40,497)
6	<i>ҮХХАТатвар</i>	11	16,630	16,630	0
	<i>АТБӨЯХАТатвар</i>	12	209	209	0
	<i>Орлогын албан татвар</i>	13	139,000	184,698	(45,698)
	<i>Санхүүгийн аудит</i>	14	11,000	9,500	1,500
	<i>ЖХАЖДаатгал, ГХДаатгал</i>	15	3,987	287	3,701
7	Конторын байр, гражийн ашиглалтын зардал	16	50,188	48,604	1,584

8	Шатахуун,сэлбэг хэрэгсэл , засвар үйлчилгээний зардал	17	108,600	158,258	(49,658)
9	Харилцаа холбооны зардал	18	25,281	23,570	1,711
10	Сургалт, судалгаа, шинжилгээний зардал, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны зардал	19	200,000	164,799	35,201
11	Даатгалын тохиолдлын хохирол үнэлгээний зардал	20	10,000	2,650	7,351
12	Бусад	21	10,000	3,381	6,619
13	Oracle Support сунгалт	22	140,000	140,000	0
14	Office 365 (1 жилийн сунгалт-14x600.0)	23	8,400	3,517	4,883
15	Fortigate 100F licence (сунгалт)	24	25,000	23,064	1,936
16	"Oracle administration workshop"-н сургалт	25	6,000		6,000
17	Server SSD hard (8x1300.0)	26	10,400	8,414	1,986
18	Server RAM (16x1200)	27	19,200	5,000	14,200
19	BI програм, суурилуулалт	28	25,000		25,000
20	Мэдээллийн аюулгүй байдал,ISO 27001 нэвтрүүлэх зардал	29	50,000	10,000	40,000
	<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>30</b>	<b>1,773,327</b>	<b>1,515,883</b>	<b>257,444</b>
д/д	<b>Хөрөнгө оруулалтын зориулалт</b>	Мөрийн дугаар	Төсөв	Зардлын гүйцэтгэл	Хэтрэлт - Хэмнэлт +
21	Storage server, switch	31	280,000.0	280,000.0	0
22	Oracle RAC replication суулгах	32	20,000.0	20,000.0	0
23	Компьютор тоног төхөөрөмж шинэчлэх	33	20,219.0	19,868.0	351
24	UPS battery солих	34	9,600.0		9,600
	<b>Хөрөнгө оруулалтын зардлын дүн</b>	<b>35</b>	<b>329,819.0</b>	<b>319,868.0</b>	<b>9,951</b>
	<b>Нийт зардлын дүн</b>	<b>36</b>	<b>2,103,146</b>	<b>1,835,751</b>	<b>267,395</b>
25	<b>Жолоочийн даатгалын сангаас олгох нөхөн төлбөр</b>	37	150,000.0	106,149.4	43,851

2024 оны төсвийн гүйцэтгэлээс үзэхэд төсөвлөсөн зардлуудыг батлагдсан төсвөөс хэтрүүлээгүй бөгөөд хэмнэсэн байна.

Даатгалын сан, холбооны 2023 оны хөрөнгийн байдлыг 2024 онтой харьцуулан харуулбал:

### Санхүүгийн хураангуй тайлан

Хүснэгт16 /мян.төг-өөр/

Д.д	Балансын зүйл	2023 он		2024 он	
		ДТ	КТ	ДТ	КТ
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	74,600.2		197,246.2	

2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	11,858,224.2		12,138,646.1	
3	Авлага (Цэвэр)	6,088,788.2		6,385,044.3	
4	Урьдчилж гарсан зардал			3,945.2	
5	Үндсэн хөрөнгө (Цэвэр)	1,638,683.9		1,705,018.8	
6	Биет бус хөрөнгө (Цэвэр)	124,956.9		89,586.3	
7	Дансны өглөг		2,303.4		3,121.5
8	Цалингийн өглөг				
9	Татвар хураамжийн өглөг		280.0		22,545.9
10	Жолоочийн даатгалын сан буюу хязгаарлалттай нөөц		19,769,857.0		20,487,955.2
11	Хязгаарлалтгүй нөөц буюу холбооны өөрийн хөрөнгө		12,813.0		5,864.3
<b>ДҮН</b>		<b>19,785,253.4</b>	<b>19,785,253.4</b>	<b>20,519,486.9</b>	<b>20,519,486.9</b>

Тайлант хугацааны үндсэн үйл ажиллагааны зардал 1,724,300.2 мянган төгрөг, хүүний орлогын албан татвар 184,697.6 мянган төгрөг, НБББББ-ийн 3.3 дахь тусгай бодлогын дагуу байгуулсан найдваргүй авлагын зардал 81,075.6 мянган төгрөг. Нийт зардал 1,990,073.4 мянган төгрөг. 2024 онд батлагдсан төсвөөс хэтэрсэн зардалгүй, төсвийн зарцуулалтыг зардлын зүйл бүрээр хянаж ажиллалаа. Жолоочийн даатгалын санд 2,708,171.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 1,990,073.4 мянган төгрөг зарцуулж ажилласнаар 718,098.2 мянган төгрөгөөр сангийн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup>.1-д албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна гэж заасан байдаг. Холбооны хөрөнгө гишүүдийн элсэлт, тухайн жилийн татвараас үндсэндээ бүрдэж байгаа бөгөөд Удирдах зөвлөлөөс баталсан зориулалтын дагуу зарцуулагдаж байна.

**Дотоод хяналт:** Удирдах зөвлөлөөр батлагдсан Холбооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нэгжүүдийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал баталж төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 14 хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж 58 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 88,7 хувийн биелэлттэй 11,3 хувь нь хэрэгжих шатандаа явж байна.

Тайлант хугацаанд дотоод хяналтаас Серверийн өрөө түүнийг ашиглах журам, Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмуудын төслийг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Даатгалын компаниудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хянаж, 2023, 2024 онуудад санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг харьцуулан аудитын зөвлөмжийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хянасан нь:** Тайлант хугацаанд “Холбооны ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай”, “Холбооны ажлын албаны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлах тухай”, “Жолоочийн даатгалын сангийн 2025 оны бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийг батлах тухай”, “Холбооны гишүүнээр элсүүлэх тухай”, “Холбооны гишүүний хураамж, татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай”, “Жолоочийн даатгалын сангийн

2025 оны бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийг батлах тухай” нийт Удирдах зөвлөлийн 7 тогтоолыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Хууль, эрх зүйн хэрэгжилт:** Санхүүгийн Зохицуулах хорооноос Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хуульд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлж буй хуультай харьцуулсан судалгааг гарган 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/60 тоот алба бичгээр саналыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 3/3272 тоот албан бичгээр дараах журмуудад санал өгсөн. Үүнд: “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар”, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам”, “Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам”, “Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам”, “Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”, “Даатгалын тохиолдлын тодорхойлолтыг бүрдүүлэх заавар”, “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”, “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам”, “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”, “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”.

Холбоонд тайлант хугацаанд нийт ирсэн баримт бичиг 192 байгаагаас хугацаа хэтэрсэн хариу өгөөгүй бичиг байхгүй ба явуулсан баримт бичиг нийт 208 байна.

Нийт 91 өргөдөл, гомдол ирсэн ба үүнээс Холбооны ажилтнуудын 50 хүсэлт, нөхөн төлбөрийн болон бусад 41 өргөдөл хүлээн авч ажилтнуудтай холбоотой 45 тушаал, нөхөн төлбөр болон бусад 36 тушаал шийдвэр гаргасан байна.

Холбооны Гүйцэтгэх захирлын Ажлын албаны бүтэц орон тоог шинэчлэн зохион байгуулах тухай 2024 оны 02 дугаар сарын 01-ний Б/08 тушаалын дагуу ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, батлуулан хөдөлмөрийн гэрээг байгуулсан. Ажилтнуудын цагийн бүртгэлийг ERP-Mongolia системийн цаг бүртгэлийн ERP E-Chat-апп- аар бүртгэж хэвшүүлсэн.

Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлж Холбооны эд хөрөнгийн тооллогыг нягтлан шалгах, тулгах, ажлын байрны засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Гадаад хамтын ажиллагаа:** 2024 оны 02 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд БНСУ, Сөүл хотод, СЗХорооны дэд дарга Б.Цэрэнбадрал, Удирдах зөвлөлийн гишүүн З.Батболд, Гүйцэтгэх захирал М.Өлзийбат нар “Samsung Fire & Marine insurance”, SongSil Их Сургуулийн Профессор ChangSoLee, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан дарга Ghreum Ahn-тай уулзаж АЖДХ-оос хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх ажлуудын талаар мэдээлэл өгч иргэдийн скоринг, итгэлцүүр тооцох, хиймэл оюун ухаан, замын хөдөлгөөний зөрчлийн үнэлгээний систем, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон. Олон Улсын Валютын Сангийн Төсвийн асуудал эрхэлсэн газрын Монголын хөтөлбөрийг хариуцсан эдийн засагч Майкл Хардигаар ахлуулсан үнэлгээний багтай уулзалт, цаашдын

хамтын ажиллагааны талаар ярилцсан. Германы хамтын ажиллагааны олон улсын байгууллагын зөвлөх Антонис Малагардистэй уулзаж хамтын ажиллагаа, ТТ талаар ярилцсан.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

**Дүгнэлт:** Холбоо нь 2024 онд батлагдсан үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж хэмнэлттэй ажилласан байна. Даатгалын компаниудын хураамжийн дүнгийн ялгаа их харагдаж байна. Топ компаниуд зах зээлд давамгайлж байгаа тул жижиг компаниудад өрсөлдөөний чадвар нэмэх шаардлагатай байна. Системээс гарсан тоо мэдээллээс харахад Мэргэшсэн гэрээний тоо бага байгаа нь Илүү мэргэшсэн даатгалын үйлчилгээ үзүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

2024 онд Холбооны хувьд Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад хууль, журам, дүрэм, зааврийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Даатгагч, даатгуулагч, хохирогч, зуучлагчид жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоо, ашиг сонирхлыг хангаж жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулах, даатгалын тохиолдол, нөхөн төлбөр, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, суртчилгааг санхүүжүүлэх, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэж байна. МIIS системийг өргөжүүлэн хөгжүүлж ХУР, ДАН системтэй холбож, мэдээлэл дамжуулдаг болгох ажлыг бүрэн хийж дуусгасан төдийгүй дэвшилтэд технологид суурилсан интегралчлах чадвартай даатгалын салбарын мэдээллийн нэгдсэн сангийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын системийг нэвтрүүлсэн нь даатгалын салбартаа мэдээллийн системийн томоохон шинэчлэлийг хийж чадсан нь сайшаалтай хэрэг боллоо. Албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад мэдээллийн үйл ажиллагааг бүрэн чиглүүлж даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийг бүрэн зориулж байгаа төдийгүй бусад эх үүсвэрээс ч хөрөнгө зарцуулж байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Жолоочийн даатгалын сангаас 2024 онд даатгалгүй 21 жолоочийн бусдад учруулсан хохирлын 97,421.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байгаа нь Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилт тодорхой хэмжээнд хэрэгжиж зохих үр нөлөө үзүүлсэн байна. Зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, суртчилгааны ажлыг зорилтот бүлгүүдэд Жолоочийн даатгалын хуулийг дэлгэрүүлэн тайлбарлаж хүргэснээр Даатгалд хамрагдалт нэмэгдэх, Даатгалын тохиолдлын үед талуудын оролцоо, хуулийн мэдлэг, даатгалын ач холбогдлыг мэдрүүлэх, цаашлаад даатгалын тохиолдлыг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна. Холбооны зүгээс Чингис хаан банкинд 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/45 албан тоот “Хүсэлт хүргүүлэх тухай”, 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 1/85 албан тоот “Гэрээний хэрэгжилтийг хангах тухай”, 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/121 тоот “Мэдээлэл хүсэх тухай”, Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/25 тоот, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 1/100 албан тоотуудаар тус тус “Хөрөнгө татах тухай” албан тоот илгээж шаардлага тавьж ажилласан ба 2024 оны эхний хагас жилд Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас 2 удаагийн гүйлгээгээр 10,0 сая төгрөг татан төвлөрүүлсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 24/122 тоот “Төлбөр барагдуулах гэрээ”-гээр харилцах дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийн холбогдох хэсгийг хөрөнгөөр барагдуулахыг зөвшөөрсөний үндсэн дээр 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 24/123 тоот “Эрх шилжүүлэх гэрээ”-

гээр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороонд байрлах “Гарден хилл” хотхоны орон сууцны барилгын 2-р ээлжийн 661 байрны 1 давхарын 101 тоот 40.22м.кв 2 өрөө орон сууцыг 118,649,000.0/Нэг зуун арван найман сая зургаан зуун дөчин есөн мянга/ төгрөгт дүйцүүлэн шилжүүлэн өгсөн байна.

#### **Цаашид дэвшүүлсэн зорилт:**

Холбоо 2024 онд “Технологийг дэмжсэн хариуцлагын даатгалын тогтолцоог өргөжүүлэх ” зорилго дэвшүүлсэн. Үүнд:

1. Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг бүрэн цахимжуулна.
  - Гэрээ
  - Нөхөн төлбөр
  - Буцаалт
2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
  - Үнэлгээ хийнэ
  - Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандарт нэвтрүүлнэ
3. Дата үнэн зөв байдлыг хангана
4. Холбооны дотоод үйл ажиллагааг цахимжуулна
  - Дотоод бичиг хэргийн
  - Дуудлагын
  - Chatbot
5. Сургалт, сурталчилгаа
  - Даатгалын байгууллагуудтай
  - Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай
6. Олон улсын гадаад хамтын ажиллагаа
  - Төсөл хөтөлбөрт хамрагдах, судалгаа явуулах
  - Сайн туршлага нэвтрүүлэх

#### **ТАЙЛАН БИЧСЭН:**

**АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ**

**Б.СОЁЛМАА**

**МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АХЛАХ АДМИН**

**О.МӨНХБАТ**

**ДААТГАЛЫН САН, ШУУРХАЙ**

**АЛБАНЫ СУРГАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР**

**Б.ГҮНДЭГМАА**

#### **ТАЙЛАН НЭГТГЭСЭН:**

**ДОТООД АУДИТОР**

**Ц.ЭНХТУУЛ**

#### **ХЯНАСАН:**

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН**

**ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**М.ӨЛЗИЙБАТ**